



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1.“Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Жамъянжавын Бадрахыг өөрийнх нь хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцалж, Ж.Бадрахын тус газарт 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдөр гаргасан хүсэлт болон түүнд олгох тэтгэмжийн асуудлыг хэлэлцэн холбогдох журам, гэрээний дагуу шийдвэрлэх;

1.2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01/2289 дүгээр албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/10805 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Чүлтэмийн Алтанбаганыг “Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар холбогдох хууль тогтоомжийн дагуу томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ